

Налайх Дүүргийн 5-р хороонд байрлах 5 га ойн төглийн талбайд гүний худаг гаргах ажил гүйцэтгэлийн удирдамж

Байгууллага: Хүүхдийг Ивээх Сан ТББ
Төслийн нэр: Ойн төгөл бүтээгч хүүхдүүд
Байршил, хэмжээ: Налайх Дүүргийн 5-р хороонд байрлах 5 га
/X 5293407.735; Y 669067.458; Н 1460.883/
Төсвийн шугам: 1,1,2
Ажлын зорилго: 5 га ойн төгөлд гүний худаг гаргах ажил
Ажил гүйцэтгэх хугацаа: 2025.08.01 – 2025.08.10

1. Үндэслэл

Японы Хүүхдийг Ивээх Сан /ХИС/ нь хүүхдийн эрхийг хангах, түүнийг хэрэгжүүлэх замыг боловсронгуй болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, ашгийн бус, шашны бус, олон улсын төрийн бус байгууллага юм.

ХИС нь 2024 оны 08 сараас эхлэн Налайх дүүрэгт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад иргэд, хүүхэд багачуудын оролцоотойгоор ойжуулах, ногоон орчныг бий болгох зорилготой “Ойн төгөл бүтээгч хүүхдүүд төсөл”-ийг хэрэгжүүлж эхэлсэн.

Төслийн зорилго нь Налайх дүүргийн зорилтот бүсэд мод тарих, хүүхэд, залуучуудын дунд уур амьсгалын өөрчлөлтийн мэдлэг мэдээллийг түгээж, мэдээлэл, сурталчилгааны аяныг өрнүүлэх замаар хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах дэлхий нийтийн зорилгод хувь нэмрээ оруулах юм. Төслийн үйл ажиллагааны үр дүнд орон нутгийн иргэд, хүүхэд, залуучууд уур амьсгалын өөрчлөлтийг сөрөх, тэсвэрлэх, дасан зохицох мэдлэг, ур чадвартай болно.

2. Гэрээт ажлын зорилго

ХИС ийн Налайх дүүрэгт хэрэгжиж буй “Ойн төгөл бүтээгч хүүхдүүд төсөл”-ийн 5га талбайд зохих стандарт шаардлагын дагуу усалгааны усаар тогтвортой хангах зорилгоор гүний худаг гаргах, насос суурилуулах, ус хадгалах систем байгуулах, худгийн хамгаалалт бүхий гаднах байгууламжийг хийж гүйцэтгэнэ.

3. Ажил гүйцэтгэх хугацаа

Гэрээ байгуулснаас хойш **7 хоногийн дотор** ажлыг бүрэн гүйцэтгэж, хүлээлгэн өгнө.

4. Техникийн үндсэн шаардлага

Газар зүйн байршил		
Байршлын координат:	GPS	X 5293407.735; Y 669067.458; Н 1460.883
Газрын байдал:	төлөв	Уул зүйн хувьд талбайн байрлал нь Хэнтийн уулархаг мужийн баруун урд хэсэгт Налайхын хотгорт хамаарагдана. Энэхүү хотгорын туйлын өндөржилт далайн түвшнээс дээш 1400-1420 м байна. Талбай байрлаж буй энгэр нь урдаас хойш сунаж байрласан толгойн зүүн урд энгэрт зүүнээс баруун тийш аажуу налуу байрлалтай, трапецууд хэлбэртэй, урдаас хойш бага зэрэг налуу тэгш гадаргуу үүсгэжээ. Хойд талаар Тэрэлжийн сарьдгийн баруун урд үзүүрийн салбар хадат шовх сэрвэн уулс Чингэс хайрхан уул ба баруун хойно Баянзүрх уул салхины шууд

	нөөлгийг хааж, Налайхын хөндийн хойд талын нөмөрт байрлал нь салхины элэгдлийг хааж цас хунгарлах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Одоогоор малын бэлчээрт ашиглагдаж байгаа энэ талбай нь хүн суурьшиж эдэлж байгаагүй, атар газар бөгөөд зүүн урдаас хойгуур ба баруунаар нь хуучин төв зам явж байснаас усны элэгдлийн гүй ховилуудтай ба энэ нь энэ талбай руу урсаж ирэх үерийн усыг залан урсгаж элэгдлээс хамгаалж байдаг.
Газрын зориулалт	Ногоон байгууламж, ойжуулалт
Гидрогеологийн нөхцөл	
Хөрсний бүтэц:	Шинжилгээний ерөнхий дүн: Ялзмагийн агууламж багатай 0.84 - 1.7 % Хөрсний орчин pH саармаг pH 7.04 - 7.28 Нитратын азот NO ₃ бага хангалттай Хөдөлгөөнт фосфор P ₂ O ₅ бага хангалттай Солилцох кали K ₂ O дунд хангалттай
Усан сүлжээ (урьдчилсан судалгаагаар):	Усан сүлжээний хувьд талбайн хойгуур Туул гол ойролцоогоор 400 м-т зүүнээс баруун тийш урсан өнгөрөх ба Туул голын усны урсац нэлээд тогтворгүй, зун борооны үед голын усны түшингийн хоногийн хэлбэлзэл 50-60 см-ээр дээшилж эргээ урагш хальдаг. Туул голын усны урсгалын хурд 1.2 м/сек, голын усны өргөн 30-70 м гүн нь 0.8-3.5 м, олон жилийн ажиглалтын мэдээгээр голын усны зардлыг 101 м ³ /сек гэж тогтоосон байна. Мөн талбайн баруун урд хэсэгт булаг ундрах ба урсах явцыг өндөр далан барьж хааснаас жижгэвтэр хиймэл нуур үүсэж тогтмол устай байдаг, нуур нь цэнгэг устай, усны ба эргийн ургамалжилт ихтэй шавж үржих таатай нөхцөлтэй тул усны шувууд их чуулдаг байна. Нуурын баруун энгэрт Нисэх хотхоны цэвэрлэх байгууламж байрлаж түүнээс гарсан хаягдал ус хөрсөнд шингэн нуурт нийлж далангаас хойш товлосон талбайн баруунаар захлан газрын доогуур тус нуурын устай хамт Туул голд урсан нийлдэг.
Худгийн үзүүлэлт	
Хоолойн диаметр:	168 мм ээс доошгүй (HDPE/металл)
Ханын бэхэлгээ:	PVC/металл, 6–10 атм даралт даах чадвартай
Насосын систем	
Насосын төрөл:	Гүний насос (нарны/цахилгаан хосолсон)
Ус татах хүчин чадал:	Худгийн гүн усны гарц 1,8 л/ сек-аас доошгүй
Цахилгаан, энергийн эх үүсвэр	
Нарны хавтан:	1.5–2.5 кВт багтаамжтай 5кв -дээш чадалтай
Батарей:	Хуримтлуулалтай систем бүхий цэнэг хуримтлуулагч, өсгөгч систем
Цахилгаан:	Цахилгааны эх үүсвэртэй холбож, 24 цаг ажиллуулж, шавхалт хийж хүлээлгэж өгөх
Ус хадгалах систем	
Усны нөөцийн сав:	3–5 м ³ 5м ³ - дээш багтаамжтай, усны оролт гаралтын хоолойтой. Усан санг талбайн өндөрлөг цэгт бетон суурин дээр байршуулж усны эх үүсвэр худагтай холбоно.. Усан сангийн дээр орчныг ажиглах цамхаг байгуулна.
Материал:	Төмөр, нерж

Хамгаалалтын байгууламж	
Байгууламж:	Худгийн хамгаалалтын байгууламж барих 2х2м худгийн ам, цахилгаан шитийг хамгаалсан хашаа хийх, худаг ба усан сангийн холболт


5. Аюулгүй ажиллагаа, стандарт ба чанарын баталгаа

- Ажлыг Монгол Улсын барилгын норм, дүрэм (БНБД) болон холбогдох стандартын дагуу гүйцэтгэнэ.
- Хэрэглэгчийн эрүүл мэнд болон байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Усны чанарыг холбогдох лабораторид шинжлүүлж, тохирлын шаардлагыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулна.
- Чанар, стандарт, аюулгүй байдлыг чанд мөрдөх ба усны эх үүсвэрийг бүрдүүлж, байгууламжийг бүрэн угсарч, ажиллагаанд оруулан захиалагчид хүлээлгэн өгнө.
- Цахилгаан холболтыг хяналтын самбартайгаар суурилуулж, аюулгүй байдлыг бүрэн хангана.
- Худгийн насосын баталгаат хугацаа нь 1 жилээс доошгүй байна.
- Худаг гаргасны дараа 24 цагаас доошгүй хугацаанд шавхалт хийж, ажиллагааг баталгаажуулна. Мөн ашиглалтын заавар, зааварчилгаатайгаар хүлээлгэн өгнө.
- Захиалагчид ажлын явцын тайлан өгч, түүний хяналтад ажлыг гүйцэтгэнэ.
- Техникийн болон гүйцэтгэлийн зураг төслийг худгийн гэрчилгээнд хавсаргаж, бүрэн баримтжуулсан байдлаар захиалагчид хүлээлгэн өгнө.

6. Ажил гүйцэтгэгчид тавигдах шаардлага

- Худаг гаргах тусгай зөвшөөрлийн гэрчилгээтэй байх
- Худаг гаргах ажил гүйцэтгэх хүн хүч, техник хэрэгсэл, материалын нөөцтэй байх
- Өмнө нь ижил төрлийн ажил гүйцэтгэсэн туршлагатай байх
- Чанар, стандарт, аюулгүй ажиллагааны шаардлагыг чанд мөрддөг байх

7. Байршлын газрын зураг, хэмжээ

Газрын байршлын зураг	Цэг	Зай
	1-2	174.3
	2-3	53.60
	3-4	243.04
	4-5	259.93
	5-6	130.24
	6-1	58.66

8. Ирүүлэх материалууд:

Ажлыг гүйцэтгэх сонирхлоо илэрхийлж буй байгууллага нь дараах бичиг баримтыг бүрдүүлэн ирүүлнэ. Үүнд:

- Худаг болон барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар (Холбогдох төрийн байгууллагаас олгосон хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл)
- Сонирхлын албан бичиг (Энэхүү ажлыг гүйцэтгэх хүсэл эрмэлзлээ илэрхийлсэн, байгууллагын албан ёсны бичиг)
- Байгууллагын ерөнхий танилцуулга (Үүсгэн байгуулагдсан он, чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны товч мэдээлэл бүхий танилцуулга)
- Нийт үнийн санал (Хөдөлмөр, техник хэрэгсэл, тээвэр, татвар, хураамж болон НӨАТ-ыг багтаасан нэгдсэн үнийн санал)
- Гүйцэтгэх ажлын календарчилсан төлөвлөгөө (Ажлын үе шат, хугацаа, хариуцсан багийн мэдээллийг тусгасан төлөвлөгөө)
- Өмнө гүйцэтгэсэн үйлдвэр, үйлчилгээний туршлагын жагсаалт (Сүүлийн жилүүдэд хийж гүйцэтгэсэн ижил төрлийн ажлын нэр, захиалагч, хугацаа зэрэг мэдээлэлтэй жагсаалт)
- 2024 оны санхүүгийн тайлан (Санхүүгийн тогтвортой байдлыг харуулах зорилгоор тухайн жилийн тайланг хавсаргана)

Дээрх материалуудыг битүүмжлэн дараах хаягаар хүргүүлнэ үү. Японы Хүүхдийг Ивээх Сан, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Аризона төвийн 4-р давхар. Материал хүлээн авах эцсийн хугацаа: **2025 оны 7 сарын 30-ны өдрийн 17:00 цаг.**